

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
4. 2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
5. 3. Менежментийн захидал .....	8
6. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	15
7. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
И.ТҮВШИНТОГТОХ ТАНАА

2020.02.27 № 06/618  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын албан үүргийг түр гүйцэтгэгч И.Түвшинтогтох Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн балансын данстай холбоотой асуудлаар төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.15 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-тай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн “Мэдээлэл-Аудит” ХХК” аудит хийлээ.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мэдээлэл-Аудит ХХК-ийн захирал Д.Товуудорж, аудитор Д.Туяа, шинжээч С.Наранцэцэг, Чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мэдээлэл-Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь Монгол орны ургамлын олон янз байдлыг судлах, хамгаалах, түүний генийн санг хадгалах, экологи биологи онцлогийг эд, эс, бодгаль, популяц, экосистемийн түвшинд явуулж, ургамлын нөөц тогтоох, түүнийг зохистой ашиглах, нөөцийг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, Ботаникийн цэцэрлэгийн үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий төсвийн эрдэм шинжилгээний мэргэшсэн байгууллага юм.

Үйл ажиллагааны чиглэл нь Монгол орны ургамлын аймаг, ургамалан нөмрөг ургамалшилтын тархац, нөөцийн судалгаа, ургамлыг тархималжуулах, нутагшуулах оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч, байгалийн нөөцийг тогтвортой ашиглаж, нөхөн сэргээж, экологийн тэнцвэртэй аюулгүй орчинд амьдарч ажиллах зорилтыг дэвшүүлж, “Ногоон хөгжил”-ийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгон, “Ногоон эдийн засаг”-ийн тогтолцоог бүрдүүлж, экологид ээлтэй тэргүүлэх арга, технологи, шинжлэх ухааны ололтыг судалж нутагшуулах, дотоодын судалгаа шинжилгээ, технологи боловсруулах чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаал цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ыг мөрдөн ажиллаж байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитын 3 чиглэлд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 364,164.3 мянган төгрөгөөс тооцон 3,641.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор 2019 оны 09 дүгээр сарын 16-ний өдөр Хуулийн этгээдээр бүртгүүлэн үйл ажиллагаагаа эхлээд байна. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо дансанд үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	140,0	140,0
Бараа материал	0.0	3,352.2	3,352.2
Үндсэн хөрөнгө	0.0	3,559,552.2	3,559,552.2
Үндсэн хөрөнгийн элэгдэл	0.0	-26,233.5	-26,233.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>3,536,810.8</b>	<b>3,536,810.8</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	3,547,301.4	3,547,301.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>0.0</b>	<b>3,536,810.8</b>	<b>3,536,810.8</b>

Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь 63 орон тоотойгоор 2019 оны 09 дүгээр сарын 01-ээс эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэл болгон хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, эхлэлтийн балансаар 3,547,301.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр нь авч эрдэм шинжилгээний зардлаас санхүүжүүлэн 11,370.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 880.0 мянган төгрөгийн санхүүгийн програм худалдан авч нийт 12,250.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд 26,233.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо 3,547,301.4 мянган төгрөг, тайлант хугацааны үр дүн 3,535,367.3 мянган төгрөг байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх урсгал үйл ажиллагааны зардалд зориулан 291,040.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Улсын төсвөөс 291,040.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанаас 450.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 290,868.8 мянган төгрөг зарцуулж 621.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290,868.6 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь зардлыг хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 65,481.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 31,222.2, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3,027.8, хангамж бараа материалын зардалд 5,401.4, эд хогшил худалдан авахад 9,486.5, томилолт зочны зардалд 2,550.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 13,646.7, нийт 65,334.6 мянган төгрөгийг зарцуулсан үлдэгдэл 147.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

#### **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 1,303.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд аудитын зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 50 мэдээлэл байршуулахаас 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь 2019 оноос шинээр үүсгэн байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа тул өмнөх онд аудит хийгдээгүй.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Баланы данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д 1,303.6 мянган төгрөгийн өртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалтыг зөрчиж байна.

#### 3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдэл зөрчигдөх;
- Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тайлант хугацаанд өр, авлага үүсгэхгүй төсвийг зохистой удирдан ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,492,166.67</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>140,000.00</b>
33300	Татаас санхүүжилтийн авлага		140,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>3,352,166.67</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>3,352,166.67</b>
35410	Бичиг хэргийн материал		239,500.00
35420	Аж ахуйн материал		2,546,000.00
35440	Түлш, шатах тослох материал		440,000.00
35470	Бусад хангамжийн материал		126,666.67
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,533,318,651.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>3,533,318,651.35</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>499,169,151.35</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		325,065,874.45
39202	Хуримтлагдсан элэгдэл		-7,870,004.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл		785,714.24
39204	Хуримтлагдсан элэгдэл		-87,301.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		51,834,860.70
39206	Хуримтлагдсан элэгдэл		-8,807,035.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		1,631,419.47
39208	Хуримтлагдсан элэгдэл		-45,629.76
39214	Бусад үндсэн хөрөнгө		141,353,626.80
39215	Хуримтлагдсан элэгдэл		-9,423,575.12
39217	Ном		4,731,202.39
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>3,034,149,500.00</b>
39301	Програм хангамж		880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		3,033,269,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,536,810,818.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>1,443,558.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>1,443,558.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>1,443,558.00</b>
	Байгууллагад төлөх өглөг		1,443,558.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,535,367,260.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>3,535,367,260.02</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		3,547,301,398.05
51101	Өмч: - төрийн		3,547,301,398.05
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>-11,934,138.03</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		-3,547,301,398.05
51220	Тайлант үеийн үр дүн		3,535,367,260.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,536,810,818.02</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>3,904,273,578.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>3,547,891,398.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>3,547,891,398.05</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,547,891,398.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	450,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	3,547,301,398.05
120009	Бусад орлого	-	140,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>356,382,180.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	<b>291,040,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	291,040,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>65,341,580.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,381,580.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	51,960,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>368,906,318.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>368,906,318.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>366,277,521.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>266,455,863.87</b>
210101	Үндсэн цалин	-	200,304,863.87
210102	Нэмэгдэл	-	59,151,000.00
	Гэрээтийн цалин	-	7,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>32,382,885.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	28,212,512.74
210202	Тэтгэмжийн даатгал	-	621,373.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	946,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	236,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,366,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>3,703,558.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	3,703,558.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>5,890,900.00</b>
210401	Бичиг хэрэг	-	975,100.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,587,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	100,000.00
210404	Ном, хэвлэл	-	2,270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	958,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>9,689,000.00</b>
	Багаж хэрэгсэл	-	133,000.00
210604	Урсгал засвар	-	9,556,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>2,550,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	2,550,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>19,371,767.33</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	19,371,767.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>26,233,546.70</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	26,233,546.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>2,628,796.39</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>2,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>628,796.39</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	628,796.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	-	<b>3,535,367,260.02</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	-	<b>3,535,367,260.02</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>00</b>	<b>356,972,180.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00</b>	<b>590,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00	590,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00	450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00	450,000.00
120009	Бусад орлого		140,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00</b>	<b>356,382,180.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00	<b>291,040,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00	291,040,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00</b>	<b>65,341,580.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	13,381,580.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00	51,960,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>00</b>	<b>344,721,380.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00</b>	<b>344,721,380.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>00</b>	<b>341,952,583.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00	266,455,863.87
210101	Үндсэн цалин	00	200,304,863.87
210102	Нэмэгдэл	00	59,151,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00	7,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00	<b>32,382,885.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	00	27,650,885.74
210202	Тэтгэмжийн даатгал	00	1,183,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00	946,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00	236,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00	2,366,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>00</b>	<b>2,400,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	00	2,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>8,501,400.00</b>
210401	Бичиг хэрэг	00	1,169,600.00
210402	Тээвэр, шатахуун	00	2,027,400.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	00	100,000.00
210404	Ном, хэвлэл	00	2,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00	2,904,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00</b>	<b>10,289,000.00</b>
210604	Урсгал засвар	00	10,289,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00</b>	<b>2,550,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00	2,550,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00</b>	<b>19,373,434.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	19,373,434.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00</b>	<b>2,768,796.39</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00</b>	<b>2,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,000,000.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00	768,796.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00	768,796.39
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00</b>	<b>12,250,800.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00</b>	<b>12,250,800.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00</b>	<b>12,250,800.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00	12,250,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00	12,250,800.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00</b>	<b>(12,250,800.00)</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	00.00	00.00
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,547,301,398.05	-	-3,547,301,398.05	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	3,547,301,398.05	00.00	-3,547,301,398.05	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,535,367,260.02	3,535,367,260.02
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,547,301,398.05	00.00	-11,934,138.03	3,535,367,260.02

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	100
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>291,040,600.00</b>	<b>290,868,750.61</b>	<b>171,849.39</b>	<b>100</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>291,040,600.00</b>	<b>290,868,750.61</b>	<b>171,849.39</b>	<b>100</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	289,040,600.00	288,868,750.61	171,849.39	100
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>235,276,400.00</b>	<b>235,233,642.87</b>	<b>42,757.13</b>	<b>100</b>
210101	Үндсэн цалин	235,276,400.00	176,082,642.87	59,193,757.13	75
210102	Нэмэгдэл	-	59,151,000.00	(59,151,000.00)	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,484,200.00</b>	<b>29,355,107.74</b>	<b>129,092.26</b>	<b>100</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,752,200.00	24,623,107.74	129,092.26	99
210202	Тэтгэмжийн даатгал	1,183,000.00	1,183,000.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,400.00	946,400.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	236,600.00	236,600.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	2,366,000.00	2,366,000.00	-	100
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,400,000.00</b>	<b>2,400,000.00</b>	-	<b>100</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,400,000.00	2,400,000.00	-	100
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,100,000.00</b>	<b>3,100,000.00</b>	-	<b>100</b>
210401	Бичиг хэрэг	300,000.00	300,000.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	100,000.00	-	100
210404	Ном, хэвлэл	1,800,000.00	1,800,000.00	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00	-	100
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,300,000.00</b>	<b>8,300,000.00</b>	-	<b>100</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	-	
210604	Урсгал засвар	8,300,000.00	8,300,000.00	-	100
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,480,000.00</b>	<b>10,480,000.00</b>	-	<b>100</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,480,000.00	10,480,000.00	-	100
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	-	<b>100</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	-	<b>100</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>291,040,600.00</b>	<b>291,868,750.61</b>	<b>171,849.39</b>	<b>100</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>291,040,600.00</b>	<b>291,418,750.61</b>	<b>621,849.39</b>	<b>100</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	291,040,600.00	290,418,750.61	621,849.39	100
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>450,000.00</b>	<b>(450,000.00)</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	450,000.00	(450,000.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-		
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>63</b>	<b>63</b>	-	<b>100</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	-	
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>65 334 633</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>65 334 633</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>65 334 633</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>31 222 221</b>
210101	Үндсэн цалин		24 222 221
210105	Гэрээт ажлын хөлс		7 000 000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>3 027 778</b>
210201	Тэтгэврийн даатгал		3 027 778
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>5 401 400</b>
210401	Бичиг хэрэг		869 600
210402	Тээвэр, шатахуун		1 527 400
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		500 000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2 504 400
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>9 486 500</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		7 497 500
210604	Урсгал засвар		1 989 000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>2 550 000</b>
210702	Дотоод албан томилолт		2 550 000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>13 646 734</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		13 646 734
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>65 481 580</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>65 481 580</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13 521 580
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		51 960 000
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>		
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		



### 5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
<b>2020.02.18</b>			САГ-2020/356/13-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ"ТӨХК-д 1,303.6 мянган төгрөгийн өртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д " <i>төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх</i> " гэсэн заалтыг зөрчиж байна.	1,303.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Л.Жаргал
	<b>Дүн</b>	<b>1,303.6</b>			





## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines intended for writing the conclusion.